



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/309

Улаанбаатар хот

Ажиллах журам, бүрэлдэхүүн  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.6, 33.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1, 13.7, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 347 дугаар, 2020 оны "Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 155 дугаар тогтоол, Шадар сайдын 2017 оны "Журам батлах тухай" 08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын алба /цаашид "эрүүл мэндийн алба" гэх/-ны ажиллах журмыг нэгдүгээр, эрүүл мэндийн албаны штабын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, штабын бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны үйл ажиллагааг ажил үүргийн хуваарь, төлөвлөгөөний дагуу удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Штабын дарга /Ц.Эрдэмбилэг/-д үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг өөрийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулан батлуулж, шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусган ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны үйл ажиллагааны зардлыг төсөв, Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн зардалд тусган санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар /Д.Нарантуяа/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/164, А/271 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /М.Баттүвшин/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
05 дугаар сарын 14 өдрийн 309 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын алба /цаашид “эрүүл мэндийн алба” гэх/-ны гүйцэтгэх нийтлэг чиг үүрэг, салбар хоорондын хамтын ажиллагааг хангахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Эрүүл мэндийн албаны дарга нь Эрүүл мэндийн сайд байх бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн засах арга хэмжээг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдлагын бүрэлдэхүүн (цаашид “штаб” гэх)-ийг томилгоожуулан удирдана.
- 1.3. Эрүүл мэндийн алба нь Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон бусад улсын албадтай үйл ажиллагаагаа уялдуулан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.4. Эрүүл мэндийн алба нь гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийг мэргэжил арга зүйгээр хангана.
- 1.5. Бүх шатны эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журамд нийцүүлэн гамшгаас хамгаалах журам, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж ажиллана
- 1.6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага энэхүү үйл ажиллагаанд нийтлэг үүрэгтэй оролцоно.
- 1.7. Эрүүл мэндийн алба нь хандивлагч болон хүмүүнлэгийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангиудтай хамтарч ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж ажиллана.

### Хоёр. Эрүүл мэндийн албаны үйл ажиллагаа

#### 2.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ҮҮРЭГ

- 2.1.1 Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Олон улсын эрүүл мэндийн дүрмийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 2.1.2 Салбарын бодлого, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, хянах, хор уршгийг



- арилгах, хойшлуулашгүй сэргээн засах арга хэмжээг авах үйл ажиллагааны төлөвлөгөө /цаашид "гамшгаас хамгаалах төлөвлөгөө" гэх / боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн /Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны дарга/-ээр батлуулах;
- 2.1.3 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу эрсдлийн үнэлгээ хийх, эрсдлийг бууруулах, нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах, шуурхай мэдээлэл солилцох арга хэмжээг хэрэгжүүлэх;
  - 2.1.4 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, үр дүнг тооцох, шаардлагатай нөөц бүрдүүлэх;
  - 2.1.5 Үүссэн болон үүсч болзошгүй гамшиг, онцгой нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, мэргэжлийн заавар, зөвлөмж, мэдээллээр Засгийн газар, Улсын онцгой комисс, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагыг цаг тухайд нь шуурхай хангах, холбогдох шийдвэр гаргуулах;
  - 2.1.6 Гамшгаас сэргийлэх, хамгаалах чиглэлээр эрхэлсэн салбарын хэмжээнд албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, холбогдох албан тушаалтны илтгэл, мэдээлэл сонсох;
  - 2.1.7 Гамшгийн үед салбарын тогтвортой ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлэх, гамшгийн голомтод мэргэжлийн хүмүүсийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт шуурхай томилох;
  - 2.1.8 Салбарын хэмжээнд гамшгийн аюулыг зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлэх, дохиогоор ажиллах дадлага сургуулийг хийх, зарлан мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
  - 2.1.9 Хууль тогтоомжийн хүрээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, улсын албадад томилгоот хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;
  - 2.1.10 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, тайланг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улс, орон нутгийн албанаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх.

## **2.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ БҮРЭН ЭРХ**

- 2.2.1 Гамшиг, аюулт үзэгдэл, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарыг ажлын тусгай горим болон гамшгаас хамгаалах зэрэгт шилжүүлж, хуульд заасан чиг үүрэгт нийцүүлэн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 2.2.2 Эрүүл мэндийн алба нь Монгол Улсын Засгийн газрын холбогдох журам, шалгуур үзүүлэлтийг үндэслэн эрхэлсэн салбартаа гамшгаас хамгаалах бэлэн байдлын дараах зэрэгт шилжүүлэх эрхтэй. Үүнд:
  - 2.2.2.1 Өдөр тутмын бэлэн байдал
  - 2.2.2.2 Өндөржүүлсэн бэлэн байдал
- 2.2.3 Гамшгийн голомтын бүсэд хүч хэрэгсэл, мэргэжлийн бие бүрэлдэхүүн, шаардагдах техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийн хамт татан оролцуулах;

2.2.4 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой үед шаардлагатай Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, материалыг холбогдох хуулийн хүрээнд худалдан авах гэрээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах, шууд худалдан авалт хийх шийдвэр гаргах.

## **2.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.3.1 Гамшгийн эрсдэлийг үнэлэх;

2.3.1.1 Эрүүл мэндийн салбарын бүх шатанд гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, эрсдэлийн үнэлгээг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу хийлгэж, үнэлгээнд үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж ажиллана.

2.3.1.2 Гамшиг, аюул, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед салбарын тогтвортой ажиллагааг хангана.

2.3.2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;

2.3.2.1 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд бүх шатны эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн ангиудын бүтэц, үйл ажиллагаа, чиг үүргийг тусгасан байна.

2.3.2.2 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

2.3.3 Эрүүл мэндийн салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах;

2.3.3.1 Эрүүл мэндийн салбарт учирч болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг судлах, шийдвэрлах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.3.3.2 Эрүүл мэндийн салбарт учирч болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

2.3.3.3 Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийн аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангуулна.

2.3.4 Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;

2.3.4.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагааг шат дараатай болон эрчимжүүлсэн байдалд зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор бэлэн байдлын зэрэгт шилжүүлнэ.

2.3.4.2 Бэлэн байдлын зэрэгт аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хэсэгчилсэн байдлаар, шат дараалан, эсхүл шууд шилжүүлнэ.

2.3.4.3 Эрүүл мэндийн албаны дарга бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах шийдвэрийг гаргана.

2.3.5 Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;



- 2.3.5.1 Гамшгаас хамгаалах орон нутгийн эрүүл мэндийн албаны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.
- 2.3.5.2 Гамшгаас хамгаалах орон нутгийн эрүүл мэндийн албаны үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.6 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас хамгаалах сургалт зохион байгуулах, чадавхийг нэмэгдүүлэх;
- 2.3.6.1 Эрүүл мэндийн ажилтан болон иргэнийг гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас хамгаалах асуудлаар сургаж, дадлагажуулах болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.3.6.2 Гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн, иргэний гэсэн чиглэлээр сургалт явуулах орчин, нөхцөлийг хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.3.7 Гамшгийн бүртгэл, хяналт, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 2.3.7.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.3.7.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын мэдээллийн санг тохиолдлын удирдлагын тогтолцооны болон үйл явдлын мэдээлэл бүртгэх, мэдээлэх, хянах цахим программ ашиглан бүртгэж, мэдээлнэ.
- 2.3.7.3 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаархи мэдээ, тайлан гаргах, бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босгох, хяналт үнэлгээ хийх мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 2.3.7.4 Орон нутгийн алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг хүлээн авч нэгтгэх, албанаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад материалыг Онцгой байдлын ерөнхий газарт жил бүрийн 6 дугаар сарын 30, дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

## **2.4. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ГАМШГИЙН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 2.4.1 Хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, батлуулсан төлөвлөгөөний дагуу ажиллах, идэвхижүүлэх, хянах, дүгнэх арга хэмжээний зохицуулалтыг хийнэ.
- 2.4.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулна.
- 2.4.3 Эрүүл мэндийн алба нь болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжүүлэх тухай чиглэл, шийдвэр гаргана.
- 2.4.4 Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хяналт, үнэлгээ, тайлан, мэдээллийг гаргаж, үнэлгээ өгч, хариу арга хэмжээг төлөвлөж ажиллана.

## **2.5. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ГАМШГИЙН ДАРААХ ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.5.1 Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг хэвийн нөхцөлд оруулах арга хэмжээг зохион байгуулна.

### **Гурав. Эрүүл мэндийн албаны удирдлага, зохион байгуулалт**

- 3.1 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд эрүүл мэндийн албаны удирдлага, бүтэц, зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:
  - 3.1.1 Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед улсын хэмжээнд эрүүл мэндийн алба, аймаг, нийслэлийн хэмжээнд орон нутгийн эрүүл мэндийн алба /цаашид “орон нутгийн алба” гэх/ нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
  - 3.1.2 Орон нутгийн албыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга удирдан үйл ажиллагаа явуулна.
  - 3.1.3 Эрүүл мэндийн албаны штабыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, орон нутгийн албаны штабыг аймаг, орон нутгийн Эрүүл мэндийн газрын орлогч дарга ахална.
  - 3.1.4 Орон нутгийн албаны штаб нь удирдлагын багаас гадна тусгай мэргэжлийн анги, түүний бүрэлдэхүүнийг томилж, чиг үүрэг, хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг батална.
  - 3.1.5 Эрүүл мэндийн алба болон орон нутгийн алба нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхдээ төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хүмүүнлэгийн байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулна.
  - 3.1.6 Эрүүл мэндийн алба болон орон нутгийн алба нь тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхижүүлэхшийдвэр, зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй бөгөөд орон тооны бус байна.

### **Дөрөв. Эрүүл мэндийн албаны штабын үйл ажиллагаа**

- 4.1 Эрүүл мэндийн албаны штаб нь шаталсан удирдлагын тогтолцоотой байх зарчимд суурилна /бүрэлдэхүүний тайван цагийн албан тушаалын зэрэглэл, шатлал идэвхижлийн үед үйлчлэхгүй/.
- 4.2 Штабын бүрэлдэхүүн, орлох албан тушаалтан нь ажил үүргийн хуваарийн дагуу ажиллана.
- 4.3 Штаб нь Монгол Улсад бүртгэгдэж болох нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрөл тус бүрээр хариу арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг /баг/-ийг тухай бүр томилон ажиллуулж болно. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг /баг/-т яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл болон харьяа эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдийг нэмэлт хүчээр дайчлан ажиллуулна.
- 4.4 Монгол Улсад бүртгэгдэж болох нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрлийг коджуулж, салбар хоорондын мэргэжлийн байгууллагын оролцоог хангасан хариу арга хэмжээний цогц төлөвлөгөөтэй байна.



- 4.5 Гамшиг, онцгой байдал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрөл, эрсдэлийн түвшингээс шалтгаалан штаб нь хэсэгчлэн болон бүхэлдээ идэвхижиж ажиллана.
- 4.6 Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны төлөвлөгөө боловсруулж албаны даргаар хянуулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон албаны даргаар батлуулах;
- 4.7 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй арга хэмжээнд татан оролцуулах, техник, материал, хэрэгсэл зэрэг тухайн албанд шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг байлгах, хяналт тавих;
- 4.8 Эрсдэлийг бууруулах, гамшгийн үед салбарын тогтвортой ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах;
- 4.9 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгийн даатгал, санхүүгийн болон эрсдэлийн сантай холбоотой эрх зүйн зохицуулалт бий болгох;
- 4.10 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад улсын болон орон нутгийн албанаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 4.11 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэх, гарсан дүгнэлт шийдвэрт үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөн эрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 4.12 Орон нутгийн албаны штаб, мэргэжлийн ангийг сургаж дадлагажуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 4.13 Гамшгийн зарлан мэдээллийг тодотгох, гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах, сургалтын материал, гарын авлага боловсруулах;
- 4.14 Бусад улсын алба болон Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөөнд жилд нэгээс доошгүй удаа, гамшгийн үед тухай бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хамтын ажиллагааг зохион байгуулах;
- 4.15 Гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох улсын болон орон нутгийн алба, байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;
- 4.16 Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудад зориулсан гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын сургалтын тогтолцоог бий болгох, нэгдсэн хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулах;
- 4.17 Орон нутгийн алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг уг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас хүлээн авч нэгтгэх, эрүүл мэндийн албанаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээг Онцгой байдлын ерөнхий газарт хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлж ажиллах;
- 4.18 Штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилгоо хийж, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр тодотгон хүргүүлэх;
- 4.19 Штабын бүрэлдэхүүн нь шаардлагатай үед шуурхай ашиглах энэхүү тушаалаар батлуулсан тусгай шифр бүхий аранз, хамгаалах хувцас хэрэгсэл, тусгай нууцлал бүхий суурин болон зөөврийн компьютер, бичиг хэргийг эрхлэх, хадгалах штабын удирдлагын өрөө тасалгаатай байна.

05 Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
дугаар сарын 14 өдрийн 309 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



**Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны  
штабын бүрэлдэхүүн**

Шифр	Гамшгаас хамгаалах албан үүрэг	Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
01	Албаны дарга	Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн дэд сайд
02	Штабын дарга	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
03	Штабын орлогч	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
04	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Мэдээллийн технологийн хэлтсийн дарга	Эрүүл мэндийн яамны Эрсдэлийн харилцаа, хариу арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
05	Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга	Эрүүл мэндийн яамны Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч
06		Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга
07	Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга	Эрүүл мэндийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга



08	Нөөц, хангалт хариуцсан ажилтан	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга Эм хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмж, төлөвлөлтийн асуудал хариуцсан дэд дарга
09	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн яамны Химийн аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн
10	Хариу арга хэмжээ хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Эрүүл мэндийн яамны Лавлагаа шатлалын хэлтсийн дарга
11	Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Эрүүл мэндийн яамны Эрсдэлийн харилцаа, хариу арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
12	Тандалт хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ, халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтсийн дарга	Эрүүл мэндийн яамны Коронавируст халдварын хяналт, сэргийлэлт, тандалт хариуцсан ахлах шинжээч
13	Анхны тусламж, эмнэлзүйн асуудал хариуцсан ажилтан	Эрүүл мэндийн яамны Анхан шатны тусламжийн хэлтсийн дарга	Эрүүл мэндийн яамны Эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн хэлтсийн дарга
14	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагч	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн яаралтай тусламж, гамшгийн үеийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн яамны Лавлагаа шатлалын тусламжийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
15	Нууц хамгаалах ажилтан	Эрүүл мэндийн яамны Салбарын хууль эрх зүйн нэгдсэн зохицуулалт хариуцсан шинжээч	Эрүүл мэндийн яамны Хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

16	Шинэ болон сэргэж байгаа халдварын асуудал хариуцсан ажилтан	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт хариуцсан дэд захирал
17	Зоонозын өвчний асуудал хариуцсан ажилтан	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэд захирал
18	Гэмтэл, ослын асуудал хариуцсан ажилтан	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн яаралтай тусламж хариуцсан дэд захирал
19	Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ хангамж хариуцсан ажилтан	Цус судлалын үндэсний төвийн ерөнхий захирал	Цус судлалын үндэсний төвийн дэд захирал
20	Сэтгэл зүйн асуудал хариуцсан ажилтан	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал
21	Туслах, операторууд	Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологи, системийн нэвтрүүлэлт хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн яамны Анхан шатны тусламжийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан ахлах зохион байгуулагч
22		Эрүүл мэндийн яамны Сэтгэц, зан үйлийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн яамны Осол гэмтэл, хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтэн



**Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны  
штабын бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь**

**02. Штабын дарга**

1. Штабын дарга нь батлагдсан гамшгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг төлөвлөж, штабын бүрэлдэхүүнийг байнгын нэгдсэн удирдлагаар хангах;
2. Эрүүл мэндийн албаны ажлын төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын заавар, албаны даргын өгсөн чиглэлийн дагуу боловсруулах ажлыг зохион байгуулах;
3. Удирдлага, штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангиуд, нийт ажилчдын сургалт, штабын сургалтын бэлтгэл ажлыг зохион байгуулж, бичиг баримтын боловсруулалтад хяналт тавьж, холбогдох асуудлыг эрүүл мэндийн албаны даргад танилцуулж шийдвэрлүүлэх;
4. Эрүүл мэндийн албаны гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;
5. Монгол Улсад бүртгэгдэж болох нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрөл тус бүрээр хариу арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг /баг/-ийг тухай бүр томилж, үйл ажиллагааны чиглэл, ажиллах журмыг батлах;
6. Аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албадыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилд нь хяналт тавих, туслан дэмжих;
7. Онцгой байдлын ерөнхий газар, гамшгаас хамгаалах бусад албадтай ажлаа уялдуулах, хамтын ажиллагааг зохион байгуулах;
8. Нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгсэл, тандах, хэмжих, аврах ажлын багажийг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг зохион байгуулах;
9. Гамшгийн үед эрүүл мэндийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх хэвийн нөхцлийг хангахын тулд эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тогтвортой ажиллагааны судалгаа, үнэлгээ хийх ажлыг удирдах;
10. Онцгой байдлын ерөнхий газарт тухайн жилийн ажлаа тайлагнаж, гамшиг, осолтой тэмцэх тусгай үүрэг гүйцэтгэсэн бол мэдээг холбогдох дээд байгууллагад тухай бүрт нь мэдээлэх ажлыг зохион байгуулах.

**03. Штабын орлогч**

1. Штабын даргын эзгүйд орлох;
2. Удирдлага, штабын бүрэлдэхүүн, харьяа газар, эрүүл мэндийн байгууллагын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан нарыг цуглуулж бэлэн байдлыг шалгах;
3. Үндсэн болон хөдөлгөөнт удирдлагын байрыг шаардлагатай техник хэрэгслээр тоноглох, тэдгээрийн бэлэн байдлыг хангуулах;

4. Хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын тухай мэдээ цуглуулах, цагийн байдлыг үнэлэх, улсын албаны даргын тушаал, захирамж гаргах ажлыг зохион байгуулж, хяналт тавих;
5. Улсын албаны мэргэжлийн чиглэлээр тандалт, ажиглалт, хяналт, хангалтыг зохион байгуулж удирдах;
6. Гамшиг, ослын бүс, хөнөөлийн голомтод мэргэжлийн тусламж үзүүлэх, аврах ажлыг хийхэд шаардагдах техник, бараа материал, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, хангах ажлыг зохион байгуулах.

#### **04. Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан**

1. Эрүүл мэндийн албаны хэмжээнд гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээлэх системийг зохион байгуулах боломжтой техник хэрэгслийг судалж, нийлүүлэх талаар гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах;
2. Гамшгийн мэдээ, мэдээллийг дамжуулах, холбогдох техник хэрэгслийг шинэчлэх, нөхөн хангах талаар санал боловсруулж, тэдгээрийн бэлэн байдлыг хангах;
3. Эрүүл мэндийн албаны удирдлага, штабын болон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, холбогдох бусад ажилтныг цуглуулах бүдүүвчийг бололцоот бүх хувилбараар бэлтгэн сургалтын үеэр тодотгох;
4. Эрүүл мэндийн албаны үндсэн болон хөдөлгөөнт удирдлагын байрыг холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслээр төхөөрөмжлөх ажлыг хариуцан зохион байгуулж, тэдгээрийн ашиглалт, хадгалалт, бэлэн байдалд хяналт тавих;
5. Гамшгийн голомтод үүссэн цагийн байдал, түүний өөрчлөлтийн талаарх мэдээ, дамжуулах ажлыг зохион байгуулж, холбогдох газруудад мэдээлэх;
6. Гамшгийн үед мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийх, тандах ажлын хэсэг болон мэргэжлийн ангиудтай тасралтгүй холбоогоор хангах ажлыг зохион байгуулах;
7. Эрүүл мэндийн албаны бүрэлдэхүүнд холбоо, зарлан мэдээллийг цаг хугацаанд зохион байгуулах.

#### **05-06. Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан**

1. Яамны харьяа байгууллагууд болон аймаг, нийслэлийн мэргэжлийн албадын ангиудын бүтэц, хангалтын судалгаа хөтөлж, тэдгээрийн бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой сургалт, бэлтгэлийн талаар санал боловсруулан сургууль, дадлагаар шалган тодотгох;
2. Эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шаардагдах техник, хамгаалах хувцас хэрэгсэл, тусгай зориулалттай багажаар хангах ажлыг зохион байгуулах;
3. Гамшгаас хамгаалах арга ажиллагаанд мэргэжлийн ангиудын бүрэлдэхүүн, хүний нөөцийн судалгаа гаргаж, тэдгээрийг сургаж, бэлтгэхэд шаардлагатай гарын авлагыг мэргэжлийн хүмүүстэй хамтран боловсруулж ашиглах;



4. Гамшгийн голомтод мэргэжлийн ангиудыг бүлэглэн ажиллуулах, хувилбаруудыг тооцох, албаны төлөвлөгөөнд тусгаж байх;
5. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх эрүүл мэндийн албаны ажлын хэсэг, хариуцсан туслахтай хамтран санал боловсруулж шийдвэрлүүлэх;
6. Гамшгийн голомтод ажиллах өөрийн нөөцийг бусад улсын албадын болон орон нутгийн мэргэжлийн ангиудтай хамтран хуваарилах, хяналт тавих;
7. Гамшгийн цагийн байдлын өөрчлөлтийг судалж, дахин учирч болох хохирлыг үнэлэн санал боловсруулж, шийдвэрлүүлэх;
8. Эрүүл мэндийн албаны хэмжээнд гамшгаас хамгаалах сургалт явуулахад шаардлагатай танхим, талбай, зурвас байгуулах ажлыг зохион байгуулах, ашиглалтад хяналт тавих;
9. Гамшгийн үед дохиогоор ажиллах дадлага сургуулийг жил бүр зохион байгуулах;
10. Амилуулах болон анхан шатны тусламж, сэтгэл зүйн сургалтыг эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтнүүдэд явуулах.

#### **07. Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтан**

1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй арга хэмжээнд шаардлагатай техник, материал, хэрэгсэл зэрэг шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, нөөцийн мэдээллийг цахимжуулах, хяналт тавихад шаардагдах санхүүжилт, хөрөнгө оруулалтын тооцоог хийж, шийдвэрлүүлэн ажиллах;
2. Хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан цагийн тооцоог бүртгэх, цалин, нэмэгдэл хөлс, урамшууллыг тооцож олгох;
3. Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгох, гэрээ хэлцэл хийх;
4. Шаардлагатай худалдан авалтыг хууль дүрмийн дагуу шуурхай зохион байгуулах;
5. Аврах ажилд оролцох, улсын албаны мэргэжлийн ангиудыг шилжүүлэн ажиллуулах, нөхцөл байдлын өөрчлөлт орсон үед байр хүнсний болон бусад материалаар найдвартай хангах нөхцлийг судлан хангалтыг хийх;
6. Өдөр тутмын санхүүгийн тайланг штабын даргад танилцуулах, архив үүсгэн баримтжуулах;
7. Эрүүл мэндийн албаны нөөц бүрдүүлэхэд шаардлагатай эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгийн даатгал, санхүүгийн болон эрсдэлийн сантай холбоотой эрх зүйн зохицуулалт бий болгох.

#### **08. Нөөц, хангалт хариуцсан ажилтан**

1. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл нөөцийг тооцож, бүрдүүлж, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

2. Нөөцийг хадгалах, хамгаалахад шаардлагатай агуулах, байр байгууламжийн бэлэн байдлыг хангах, зохицуулах;
3. Орон нутаг, эрүүл мэндийн байгууллагад нөөцийг түгээх, аюулгүй байдлыг хангах;
4. Штабын бүрэлдэхүүнд шаардлагатай хувцас, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх хамгаалах ажлыг зохион байгуулах;
5. Аврах ажилд оролцох, эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудыг шилжүүлэн ажиллуулах, нөхцөл байдлын өөрчлөлт орсон үед байр хүнсний болон бусад материалаар найдвартай хангах нөхцлийг судлан хангалтыг хийх.

#### **09. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан**

1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амын амь нас, эрүүл мэндийг хамгаалах асуудлаар судалгаа, тооцоо хөтөлж, санал боловсруулан, албаны төлөвлөгөөнд тусгуулах;
2. Гамшгаас хамгаалах хэрэгсэлд үзлэг шалгалт хийх, тэдгээрийн бэлэн байдлыг хангах;
3. Нийслэлд тохиолдож болох гамшгаас яам, байгууллагуудын албан хаагчдыг хамгаалах асуудлыг хариуцан зохион байгуулах;
4. Эрүүл мэндийн албаны төв байрны барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам гарцын хувьд гамшгийн улмаас үүсэх эвдрэлийн зэрэг, хохирлыг тооцож аврах ажил зохион байгуулах, хохирлын нэгдсэн үнэлгээг гаргах;
5. Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор болон гамшгийн үед яам, тусгай газрын ажилтнууд, тэдгээрийн ар гэрийн хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хяналт тавих;
6. Халдвараас хамгаалах, хорио цээрийн, цацрагийн горим сахиулах болон бусад арга хэмжээг тогтоосон журмын дагуу зохион байгуулж, хяналт тавих;
7. Гамшиг болон гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах үед албаны удирдлагын байрыг шаардагдах газар нь бэлэн болгож, хамгаалалт тавин, тэдгээрийн үйл ажиллагааны хэвийн байдалд хяналт тавин ажиллана;
8. Гамшгийн үед үнэт материал, ховор тоног төхөөрөмж, аюулт химийн бодис, баримт бичгийг хамгаалан, бүртгэл хяналт явуулах;
9. Штабын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох;
10. Гамшгаас хамгаалах хэрэгслийг хадгалах, хамгаалах, бэлэн байдлыг хангах, ашиглах үйл ажиллагааг зохион байгуулах;
11. Байгууллагын байрны цахилгаан, дулаан, усны тогтвортой хангамж, хамгаалалтыг хариуцан ажиллах.

#### **10. Хариу арга хэмжээ хариуцсан ажилтан**

1. Голомтод хариу арга хэмжээ зохион байгуулах, эрсдэлийг бууруулах, голомтын халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах, цомхотгох арга хэмжээг авах;



2. Мэргэжлийн төв байгууллагуудаас томилогдон ажиллаж байгаа шуурхай арга хэмжээний баг, мэргэжлийн ангийг ажиллуулах, хувилбаруудыг тооцох, сонгон хэрэгжүүлэх, шаардлагатай заавар, зөвлөмж, албан даалгавар боловсруулан, батлуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
3. Дайчлагдан ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний өртөлтийн өмнөх болон дараах урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг хянах ажлыг зохион байгуулах;
4. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын өдөр тутмын бэлэн байдлыг хангуулах, мэдээллээр хангах.
5. Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг батлагдсан аргачлалд тулгуурлан тооцоолох холбогдох багуудыг тооцоолол бүхий мэдээллээр хангах;
6. Хариу арга хэмжээний явц, үр дүнг хянан мэргэжил, арга зүйгээр хангах;
7. Хариу арга хэмжээний тайланг нэгтгэн, танилцуулах.

### **11. Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан ажилтан**

1. Халдварт өвчний дэгдэлтийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны удирдамжтай уялдуулан үйл ажиллагааг зохион байгуулах;
2. Гамшиг, онцгой байдал, халдварт өвчний дэгдэлтийн үед итгэл төрүүлэх, эрт зарлан мэдээлэх, ил тод нээлттэй байх, олон нийтийн санаа бодлыг сонссон байх, урьдчилан төлөвлөгдсөн байх үндсэн зарчмуудыг баримтлан ажиллах;
3. Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдал, салбар дундын болон салбар хоорондын багийг мэргэжлийн хяналт, онцгой байдал, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр зэрэг холбогдох яам, агентлаг, хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоотой байгуулан хамтран ажиллах;
4. Аймаг, нийслэлийн Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны багийг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;
5. Холбогдох салбаруудтай хамтран эрсдэлийн үнэлгээ хийх, тохирсон арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
6. Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны талаар ширээний дасгал болон үзүүлэх сургууль зохион байгуулах;
7. Шинэ болон шинээр сэргэж байгаа халдваруудаас урьдчилан сэргийлэх талаар хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

### **12. Тандалт хариуцсан ажилтан**

1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлыг үүсгэгч үйл явдлын төрлөөс хамаарч эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээний тайланг штабын даргад хүргүүлэх;
2. Үйл явдлын тархалт, өрнөл, эрсдэлийг тогтоох, дэгдэлтийн судалгаа тандалт, дүн шинжилгээ хийж, хэтийн төлөвийг тодорхойлж штабын даргад танилцуулах;

3. Улс, орон нутаг, байгууллагын хэмжээнд ажиллах тандалтын багийн бэлэн байдлыг хангаж, уялдаа холбоог мэргэжил арга зүйгээр хангах, тандалт судалгаа хийх итгэмжлэгдсэн лаборатори, бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
4. Хавьтал, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, хянах, халдварын голомтыг халдваргүйжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;
5. Тандалт, тархвар зүйн чиглэлээр шаардлагатай заавар, журам, зөвлөмж, албан даалгавар, түр заавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулах батлуулах;
6. Аюулт үзэгдэл, осол, халдварт өвчний дэгдэлт, цар тахал зэргийн эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг хийх аргачлалыг нотолгоонд тулгуурлан боловсруулах, баталгаажуулах, холбогдох мэргэжилтнүүдийг сурган дадлагажуулах.

### **13. Анхны тусламж, эмнэлзүйн асуудал хариуцсан ажилтан**

1. Нэрвэгдэгсдэд гамшгийн голомтод эмнэлгийн анхны тусламж үзүүлэх;
2. Анхны тусламжийн сургалтын хөтөлбөр хамтран боловсруулах, зохион байгуулах;
3. Тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах.

### **14. Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагч**

1. Штабын нарийн бичгийн ажилтны үүрэг гүйцэтгэх;
2. Эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгийг боловсруулах;
3. Гамшгаас хамгаалах албан даалгавар, тушаал, захирамжийн төслийг боловсруулах;
4. Эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг ажилтнуудаас авч нэгтгэн боловсруулах, төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтүүдийн талаарх судалгаа, тооцоог нэгтгэх;
5. Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх асуудлын төсөл баримт бичгийг боловсруулах;
6. Эрүүл мэндийн албаны штабын баримт бичгийн эмх цэгц, хадгалалтыг хариуцах;
7. Эрүүл мэндийн албаны штабын хурлын тэмдэглэл хөтлөх, хурлын хэлэлцэх асуудлын материал бэлтгэх, шийдвэрийн төсөл боловсруулах.

### **15. Нууц хариуцсан ажилтан**

1. Нууцын албан хэрэг хөтлөлтийг хариуцах;
2. Нууц баримт бичгийн төсөл боловсруулах, баримт бичгийг гадагш илгээх, биечлэн хүргэх, архивт хадгалах;



3. Нууц баримт бичгийг зохих түвшний нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд танилцуулах, бүртгэлд тэмдэглэж баталгаажуулах;
4. Холбогдох хууль тогтоомж, төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдөн ажиллах.

#### **16. Шинэ болон сэргэж байгаа халдварын асуудал хариуцсан ажилтан**

1. Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
2. Дэлхий, бүс нутгийг хамарсан халдварт өвчин гарсан тохиолдолд тухайн өвчнөөс хүн амыг сэргийлэх төлөвлөгөө, өвчний талаарх мэдээлэл, сэргийлэх арга зүйг боловсруулан шинэчлэх, шаардлагатай тохиолдолд ДЭМБ-д хүргүүлэх мэдээллийн болон тусламж хүсэх баримт бичгийг боловсруулах;
3. Өвчин гарсан тохиолдолд тухайн халдварт өвчинтэй тэмцэх шуурхай ажлын хэсгийг зохион байгуулж, тухайн өвчний үнэн зөв мэдээллээр ханган ажиллах;
4. Шинэ болон сэргэж байгаа халдварын судалгаа, тандалт, хяналтын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;
5. Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх ажлын үр дүнг нэгтгэж, холбогдох саналыг боловсруулах.

#### **17. Зоонозын өвчний асуудал хариуцсан ажилтан**

1. Зоонозын өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
2. Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, дэгдэлт гарсан тохиолдолд тухайн халдварт өвчинтэй тэмцэх шуурхай ажлын хэсгийг зохион байгуулж, голомтыг цомтгон дарах арга хэмжээ хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд ДЭМБ-д хүргүүлэх мэдээлэл болон тусламж хүсэх баримт бичиг боловсруулах;
3. Зоонозын өвчний судалгаа, тандалт, хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж, үнэн зөв мэдээллээр ханган ажиллах;
4. Биотерроризмын үед өвчний үүсгэгчийг яаралтай тодорхойлох, түүнтэй тэмцэх ажлыг шуурхай зохион байгуулах;
5. Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлын үр дүнг нэгтгэж, холбогдох санал боловсруулах.

#### **18. Гэмтэл, ослын асуудал хариуцсан ажилтан**

1. Эрүүл мэндийн байгуулага бүрт болзошгүй гамшиг, ослын үед ажиллах багийг байгуулж ажиллуулах асуудлыг бэлэн байдлын төлөвлөгөөнд нь тусгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;
2. Аливаа гамшиг, осол болсон тохиолдолд гэмтэл, осол, мэс заслын багийг шуурхай зохион байгуулж ажиллах;
3. Гамшиг, осол болсон газарт цагийн байдлын судалгаа хийж, тусламж үйлчилгээний арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

4. Гамшиг, осолд нэрвэгдэгсдэд үзүүлэх гэмтэл, ослын, мэс заслын тусламж үйлчилгээг зохион байгуулах;
5. Нэрвэгдэгсдийн биеийн байдлыг хүнд, хөнгөн байгаагаар нь ялган ангилах /өнгөөр ялгаж таних тэмдэг зүүх/.

### **19. Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ, хангамж хариуцсан ажилтан**

1. Онцгой байдал, гамшгийн үед донор элсүүлэх, цус цуглуулах, цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, шинжлэх, нөөцлөх, тээвэрлэх, эмнэлгүүдэд түгээх үүрэг бүхий цусны асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;
2. Тайван үед цус цуглуулах 2-3 суурин цэгийг хөдөлгөөнт хэлбэрээр Улаанбаатар хотод байгуулан ажилуулан, онцгой байдал, гамшгийн үед цус, цусан бүтээгдэхүүн цуглуулах, үйлдвэрлэх, хадгалах, түгээх боломжоор хангах;
3. Орон нутагт онцгой байдал, гамшиг тохиолдсон үед тухайн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэдэх цусны салбар банкны үйл ажиллагааг өргөжүүлж, цусны төвийн хэмжээнд ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
4. Онцгой байдал, гамшгийн үед ажиллах Цус сэлбэлт судлалын үндэсний төв, цусны салбар банкууд, цус цуглуулах хөдөлгөөнт хэсгийг шаардагдах тоног төхөөрөмж, цус цуглуулах хүүдий, оношлуур, эм урвалж, сэлбэх систем, тээврийн хэрэгсэл, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж болон бусад хэрэгслээр хангах;
5. Онцгой байдал, гамшгийн үед донорын сурталчилгааг зохион байгуулах, цусны донор элсүүлэх үйл ажиллагааг Монголын улаан загалмайн нийгэмлэг, түүний салбар хороод удирдан зохион байгуулж, бусад байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулах;
6. Онцгой байдал, гамшгийн үед шаардагдах цус орлох бэлдмэлүүдийн хүрэлцээтэй нөөцийг бүрдүүлэх асуудлыг төрөлжсөн, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг болон аймаг, сум, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хариуцах;
7. Онцгой байдал, гамшгийн үед ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх, сургагдсан мэргэжилтнүүдийг шаардлагатай үед дайчлан оролцуулах асуудлыг Цус сэлбэлт судлалын үндэсний төв холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх.

### **20. Сэтгэл зүйн асуудал хариуцсан ажилтан**

1. Сургагч багш нарыг бэлтгэх;
2. Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, зөвлөх багийг томилон ажиллуулах;
3. Мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт сурталчилгаа явуулах;
4. Удирдамж, зөвлөмж боловсруулж ашиглах;
5. Нэрвэгдэгсдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх багийн үйл явцад хяналт тавих.



## 21-22. Туслах, операторууд

1. Эрүүл мэндийн жил, сарын төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг штабын ажилтнуудаас авч нэгтгэн боловсруулж, асуудал хариуцсан ажилтанд өгөх;
2. Эрүүл мэндийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтүүдийн талаарх судалгаа, тооцоог штабын ажилтнуудаас авч нэгтгэж, төлөвлөгөө боловсруулах, тодотгоход оролцох;
3. Гамшгийн голомтод үүссэн цагийн байдлын тухай мэдээллийн тайланг штабын нарийн бичгийн ажилтанд нэгтгэж өгөх;
4. Эрүүл мэндийн албаны даргын шийдвэрийг аймаг, нийслэлийн албадад шуурхай хүргэж гүйцэтгэлийг тооцон штабын орлогчид тайлагнан мэдэгдэх;
5. Эрүүл мэндийн албаны штабын хурлын төлөвлөгөөг асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран боловсруулж батлуулан, хурлын зарыг гишүүдэд хүргэж, хурлын тэмдэглэл хөтлөх;
6. Эрүүл мэндийн албаны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд оролцох;
7. Хугацаат мэдээ, тайланг аймаг, нийслэлийн албадаас авч нэгтгэж, штабын нарийн бичигт хүлээлгэн өгөх, албаны ажлын хагас, бүтэн жилийн тайланг бэлтгэх.